



# ЭРЧИМ

МЭДЭЭ

"ДЦС-4" ТӨХК-ийн сар тутмын сонин

№09 (137)

2022 оны 10-р сар

ЭНЭ ДУГААРТ:

**ИЛТГЭЛИЙН  
УРАЛДААН-2022**

2-р нүүрт

**2022 ОНЫ 9-Р  
САРЫН ТЭЗҮ**

3-р нүүрт

**2022 ОНЫ 9-Р САРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

4-р нүүрт

**ТАНЫ МЭДЭЭЛЛИЙН  
АКУУЛГҮЙ БАЙДЛЫН  
МЭДЛЭГТ**

5-р нүүрт

**"ДЦС-4" ТӨХК-Д ХҮН,  
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ,  
БАРАА МАТЕРИАЛ  
ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ  
ЖУРАМ**

6-7-р нүүрт

**АРЬС, ҮС, ХУМСНЫ  
МӨӨГӨНЦӨРТ ӨВЧИН**

8-р нүүрт



Сонины талаарх санал хүсэлтээ 2125, 2602 дугаарын утас, [sxa@tpp4.mn](mailto:sxa@tpp4.mn)

эсвэл Судалгаа Хөгжлийн Албанд файлаар болон бичгээр өгч болно.

[www.tpp4.mn](http://www.tpp4.mn)



Компанийн ажилтан ажиллагсдын дунд 2022 оны 10-р сарын 12-ны өдөр зохион явагдсан илтгэлийн уралдаанд ТДЦ, ЗЦ, ТЦ, ЗА, БМА-наас тус бүр 1, СХА-наас 2 нийт 7 хүн өөрсдийн бэлтгэсэн материалаар илтгэл тавин оролцлоо.

Уралдааныг ЕИ-ийн үүрэг гүйцэтгэгч Р.Ганбат, ҮА-ны дарга Б.Батзориг, ХА-ны дарга Ж.Энхцогт, СХА-ны менежер Б.Бадрал, ЭХС-ийн багш ШУ-ны доктор, профессор Ж.Цэен-Ойдов нар шүүн явууллаа.

Тэргүүн байрыг 122 оноогоор ЗА-ны Дүүжин тулгуур,

шугам хоолой, гагнуурын технологийн хяналт хариуцсан инженер Б.Батболд эзэлж, 1 сая төгрөг, Дэд байрыг 118 оноогоор СХА-ны зургийн инженер, техникч Л.Мягмарсүрэн Б.Билгүүн нар эзэлж, 500 мянган төгрөг, Шагналт 3-р байрыг 116 оноогоор СХА-ны судалгаа хөгжлийн инженер Н.Пүрэвхүү эзэлж, 250 мянган төгрөгийн мөнгөн шагнал өргөмжлөл хүртлээ. Мөн уралдаанд шалгарсан бусад бүтээлийн эзэд тус бүр 100 мянган төгрөг, батламж гардан авлаа.



## ИЛТГЭЛИЙН ҮРАЛДААН-2022

№	Илтгэлийн сэдвийн нэр	Нэгж, илтгэгчийн нэр
1	БКЗ-420-140-10 зуухны халах гадаргууг хатаасан агаараар хадгалалтанд тавих ажлыг зохион байгуулах.	СХА, Судалгаа хөгжлийн инженер Н.Пүрэвхүү
2	Станцын зургийн мэдээллийн сан үүсгэх	СХА, Зургийн инженер, техникч Л.Мягмарсүрэн Б.Билгүүн
3	Сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, хадгалах	ЗЦ, Цахилгаан шүүлтүүрийн цах. инженер П.Баярмагнай
4	БКЗ-420-140 маркын зуухны ПСК-н Ф159х20мм-н шугам 2 талаас нь зэрэг угсрах	ЗА, Дүүжин тулгуур, шугам хоолой, гагнуурын технологийн хяналтын инженер Б.Батболд
5	“ДЦС-4” ТӨХК-ийн хэрэглэгчийн цахим систем	БМА, Ахлах мэргэжилтэн Ч.Уран
6	Хаягдлаа боловсруулж үйлдвэрлэлийн хэрэглээнд шаардлагатай бүтээгдэхүүн гаргах	ТДЦ, Төмөр замын дохиолол, холбооны монтёр А.Эрдэнэбулган
7	Сүлжээний нэмэлт усны химийн горим	ТЦ, Баланс доргионы мастер Б.Тэмүүжин



ЗА, Б.Батболд



СХА, Л.Мягмарсүрэн



СХА, Н.Пүрэвхүү



ТДЦ, А.Эрдэнэбулган



БМА, Ч.Уран



ТЦ, Б.Тэмүүжин



ЗЦ, П.Баярмагнай



Уралдааны шүүгчид



Уралдааны хөтлөгч СХА-ны инженер Ц.Батжаргал



Үзэгчид


СХА-ны Патентийн мэргэжилтэн Ч.Баясгалан

### That Might Motivate You №7


**START PAYING ATTENTION TO WHERE YOUR TIME IS GOING**




**STOP CREATING PROBLEMS THAT AREN'T EVEN THERE**



**Success is not always what you see.**



**Sometimes you have to take a step back, just to save others.**



## 2022 ОНЫ 9-Р САРЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## Төлөвлөгөөний биелэлт

Горимын даалгавараас **5386,434** мян.кВтц цахилгаан эрчим хүч илүү үйлдвэрлэж, **150,13** мян.кВтц-аар зөрчиж, төлөвлөгөөг **5,2** сая.кВтц-аар давуулан биелүүлсэн. Цахилгаан эрчим хүчний доод ачаалал **390** МВт, дээд ачаалал **492** МВт байлаа.

## Диспетчерийн графикийн төлөвлөгөөний биелэлт

Үзүүлэлт	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт,%
ЦЭХ-ний түгээлт	сая.кВтц	277.7	282.9	+5.2	101.9%
ДЭХ-ний түгээлт	мян.Гкал	240.4	240.4		100.0%

Тайлант хугацаанд диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө: ЦЭХ - **101,9%**, ДЭХ - **100,0%** биеллээ.

## ДҮТ-ийн диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө болон биелэлт

Нэмэх шийдвэр		Хасах шийдвэр		Диспетчерийн графикийн зөрчил		Ачаалал		Диспетчерийн төлөвлөгөөний биелэлт	Диспетчерийн графикийн нэмэх зөрчил
Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Дээд	Доод	мян.кВтц	мян.кВтц
65	5386.434	21	874.832	3	150.13	492	390	5236.304	3181.2

9-р сард УСТ-д тусгагдсан ЦЭХ-ний түгээлтийг **3,0** сая.кВтц-аар давуулан биелүүлсэн. ЦЭХ-ний боловсруулалт өнгөрсөн онтой харьцуулахад **14,9** сая.кВтц-аар өссөн бөгөөд нийт өсөлтийн **29,4%**-г шөнийн бага ачаалалд, **39,1%**-г өдрийн ачаалалд, **31,5%**-г оройн оргил ачаалал тус тус эзэлсэн. Манай компани зуухнуудын хамгийн бага ачааллыг **350** т/ц-аас доош бууруулахгүй ажиллах бодлого барьж ажиллаж байгаа бөгөөд хэрэглээний бууралт гарч, экспорт нэмэгдсэнтэй холбоотой "ДҮТ ХХК" -аас **3181,2** мян.кВтц-н нэмэх зөрчил ноогдуулсан байна. Энэ сард манай компанийн үйл ажиллагааны доголдоос хамаарч диспетчерийн даалгаварыг 3 удаа зөрчсөн.

## СПОТ зах зээлийн талаар

СПОТ арилжааны зах зээлд **226,955** мян.кВтц буюу **13,0** сая.төгрөгний цахилгаан эрчим хүч худалдаж, **21,889** мян.кВтц буюу **269,969** мян.төгрөгний ЦЭХ худалдан авч, авлага өглөгийн зөрүүгээр **12,8** сая.төгрөгний ашигтай ажиллалаа. Өссөн дүнгээр **186,9** сая.төгрөгийн авлагатай.

## Үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөний биелэлт

Цахилгаан эрчим хүчний түгээлтийг төлөвлөлтөөс **3,0** сая.кВтц-аар давуулан **101,1%**-н биелэлттэй, оны эхнээс **155,9** сая.кВтц-аар давуулж, **105,6%** -ийн биелэлттэй байна. Цахилгаан эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 9-р сартай харьцуулбал **13,2** сая.кВтц буюу **4,9** %-н өсөлттэй байлаа.

Дулааны эрчим хүчний түгээлт **16,8** мян.Гкал-аар давж **107,5%**-н биелэлттэй, оны эхнээс нийт төлөвлөгөө **168,3** мян.Гкал-аар, үүнээс "УБДС" ХК –д нийлүүлэх дулааныг **159,4** мян.Гкал –аар давуулан биелүүлсэн. Дулааны эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 9-р сартай харьцуулбал **23,3** мян.Гкал буюу **10,8%**-н өсөлттэй байна.

## Үндсэн тоноглолын ажиллагаа

Горим ажиллагаанд **6** зуух, **6** турбин оролцсон. Сарын дунджаар **4,93** зуух, турбинтэй ажиллаж бэлтгэлд **1** зуух, турбин бэлтгэлгүй байлаа. Зуух №4 - дунд засварт, Зуух №8, Турбин №5 - их засварт тул ажиллаагүй.

## Нүүрсний зарцуулалт /УСТ тарифт тусгагдсан нүүрснээс/

Уурхай	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт
Багануур	мян.тн	155.0	163.5	+8.5	105.5%
Шивээ-Овоо	мян.тн	110.0	120.3	+10.3	109.3%
Бүгд	мян.тн	265.0	283.8	+18.8	107.1%

## Мазутын зарцуулалт

Энэ сард **120** тн мазут түлэх төлөвлөгөөтэйгээс **140** тн-г түлж, **20** тн мазут хэтрүүлсэн.

Тайлант хугацаанд **5** удаагийн хүйтэн галлагаа хийж **91** тонн, **1** удаагийн халуун галлагаа хийж **3** тонн мазут түлсэн. Нэг хүйтэн галлагаанд дунджаар **18** тонн мазут зарцуулсан.

## Жишмэл түлшний зарцуулалт

Цахилгаан эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлшийг - **9,672** гр/кВтц-аар, дулааны эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлшийг - **1,277** кг/Гкал-аар хэмнэж гүйцэтгэлд ноогдох төлөвлөлтөөс **3044** тн жишмэл түлш буюу **6406** тонн бодит түлш /илчлэг **3326** ккал/кг/ хэмнэсэн.

## Горим параметрийн даалгаврын биелэлт

ЭХЗХ-аас батлагдсан ДХЦЭХ-ний зарцуулалтыг **0,15%**-иар буюу **486,574** мян.кВтц-аар хэмнэж ажилласан.

Нэгж бүтээгдэхүүнд оногдох ЦЭХ-г гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөө, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй тус, тус харьцуулбал:

№	Үзүүлэлт	Нэгж	9-р сар	
			Төлөв	Гүйц
1	1 тн нүүрс нунтаглахад зарцуулах цахилгаан	кВтц/ тн.нүүрс	27.47	27.11
2	1 тн уур боловсруулахад зарцуулах үлээлт соролтын цах.	кВтц/ тн.уур	4.37	4.32
3	1 тн тэжээлийн ус шахахад зарцуулагдах цахилгаан	кВтц/ тн.тэж ус	8.38	8.27
4	Эргэлтийн усны насосд зарцуулагдах цахилгаан	%	1.47	1.46
5	Дулаанжуулалтын насосд зарцуулагдах цахилгаан	кВтц/Гкал	0.51	0.50

## Уур усны алдагдал

Станцын дотоод циклийг нөхөх химийн цэвэрлэсэн усны зарцуулалтыг төлөвлөлтөөс **1.09%** буюу **15086** тонноор хэтрүүлж ажилласан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад химийн цэвэрлэсэн усны зарцуулалт **26028** тонноор нэмэгдсэн байна. Осмосын халаагч уурын зарцуулалт **4468** тн байлаа.

Дотоод циклийн алдагдлыг нөхөхөөр:

- Турбинд - **54471** м<sup>3</sup>
- Зууханд - **393** ус өгсөн.
- БКБ-аас цэвэрлэгдсэн конденсатын зарцуулалт - **6912** м<sup>3</sup> байлаа.

**2022 ОНЫ 09-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

2022 оны 9-р сард станцын хэмжээний аваари, 1 болон 2-р зэргийн саатал гараагүй, үндсэн тоноглолын зогсолт 7 бүртгэгдсэнээс зуух 5 удаа, турбин 2 удаа тус бүр зогссон. Хүний буруутай үндсэн тоноглолын зогсолт гараагүй.

№	Зогсолтын шалтгаан	Хамгаалалтаар		Захиалгаар		Бэлтгэлд		Саатал, гэмтлээр		Нийт зогсолт	
		2021 оны 9-р сар	2022 оны 9-р сар	2021 оны 9-р сар	2022 оны 9-р сар	2021 оны 9-р сар	2022 оны 9-р сар	2021 оны 9-р сар	2022 оны 9-р сар	2021 оны 9-р сар	2022 оны 9-р сар
1	Зуух	4	1	1	1	-	-	3	3	8	5
2	Турбин	2	-	-	1	2	-	5	1	9	2
<b>Дүн</b>		<b>6</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>8</b>	<b>4</b>	<b>17</b>	<b>7</b>

**Үндсэн тоноглолын зогсолт болон туслах тоноглолд бичигдсэн актууд:**

- Тоног төхөөрөмжийн гэмтлийн акт: СБХ-1 /15,600.0 мян₮/, ЦЦ-4 /84,010.7 мян₮/, ДХХАЦ-1 /6,683.5 мян₮/, ХА-1 /300.0 мян₮/ **бүгд-7 /106,594.2 мян₮/**
  - Мазут зарцуулалтын акт: ЗЦ-5 /161,477.7 мян₮/, ЦЦ-2 /46,524.5 мян₮/ **бүгд-7 /208,002.2 мян₮/**
  - Тоноглолын аварийн зогсолтыг судалсан акт: ТЦ-1 /1,026.9/ **бүгд-1 /1,026.9 мян₮/**
  - Уур усны горимын зөрчлийг судалсан акт: ХЦ-1 **бүгд-1**
- Нийт 16 ширхэг /315,623.3 мян₮/ акт тогтоогдсон.**

**Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн байдалд хийсэн хэмжилт. (1 удаагийн)**

№	Цех нэгжүүд	Дуу шуугиан (85 дБ)		Ажлын байрны халуун (12-30 °С)		Ажлын байрны чийглэг (30-60 %)		Ажлын байрны тоосролт (10 мг/м³)		Тайлбар
		2021 оны 9-р сар	2022 оны 9-р сар	2021 оны 9-р сар	2022 оны 9-р сар	2021 оны 9-р сар	2022 оны 9-р сар	2021 оны 9-р сар	2022 оны 9-р сар	
1	ТДЦ	79.9	82.0	26.3	27.5	49.0	40.9	17.2	ЛК-3. 26.8, ЛК-4. 28.6	Тоосролт хэмжих багажны шүүлтүүр цаас хугацаандаа нийлүүлэгдээ -гүй тул бүх цэгт хэмжилт хийгдээгүй.
2	ЗЦ	84.3	77.1	31.3	26.7	37.9	35.1	10.4	К-1. 11.5, К-3. 18.9	
3	ТЦ	82.8	77.2	31.4	27.1	38.4	37.5	13.8	-	
4	Хими	70.5	71.9	26.2	23.1	47.3	45.9			
5	Механик	73.1	83.6	26.5	23.1	43.2	38.1			

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ**

1. Хяналтын чиглэлээр			
№	Хийгдсэн ажил	Гүйцэтгэл	Тайлбар
1	Нарядын мөрдөлтөнд хяналт хийсэн байдал	100%	15 нарыдад сонголтоор хяналт хийсэн.
2	Ажлын байранд хяналт хийсэн байдал	100%	9 удаа ажлын байранд хяналт хийсэн.
3	Шинэчлэл, засварын ажлын явцад хяналт хийсэн байдал	100%	К-4,8 тоосон ситемийн болон халах гадаргуун их засвар, ТА-5 -ийн засварын ажилд хяналт хийгдсэн.
2. Сургалт, зааварчилгаа			
1	Урьдчилсан зааварчилгаа өгөгдсөн байдал	100%	324 хүнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
2	Шинээр ажилд орж байгаа иргэний сургалтын талаар	100%	11 иргэнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
3	Ажлын байр өөрчлөгдсөн ажилтны сургалтын талаар	100%	16 ажилтнаас шалгалт авсан.
3. Хөдөлмөрийн эрүүл ахуйн талаар			
1	МХЕГ ХАБҮЛ лабораторитой байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих.	100%	2022.08.25 -нд гэрээний дагуу 3-р улиралд хийх шинжилгээг МХЕГ-ын ХАБҮЛ лабораторид ундны ус-3,агаар-2, хоолноос /нян-5, хими-5/ нийт -10 порц, арчдас-10 тус тус авч шинжилгээнд өгсөн. Шинжилгээний хариу хэвийн үзүүлэлттэй гарсан.
2	Хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийх.	100%	Үндсэн цехүүдэд хөдөлмөрийн нөхцлийн болон гэрэлтүүлэгийн хэмжилт хийгдсэн.
3	Ариутгал халдваргүйтгэлийн талаар	100%	Ажлын байруудад ялааны хор түрхсэн.
4	Тоосролын хэмжилтэнд хяналт хийсэн байдал	100%	Цаас тасарсантай холбоотой тоос ихтэй 2 цэг дээр 1 удаа хэмжилт хийсэн.
4. Бусад ажлын талаар			

- ТДЦ -тэй хамтарч 46 засварчинд өндрийн бүсний онол болон практик сургалтыг зохион байгуулсан.
- Зуух №8 -ийн их засварын ажилд ажиллах “СММ” ХХК -ийн ажилтнуудад урьдчилсан зааварчилгаа өгч, ЕРӨНХИЙ зөвшөөрөл олгосон.
- Цахилгаан болон гар тальтай харьцах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа ЗЦ-тэй хамтран боловсруулсан.
- ХАБЭА-н ажилтнуудыг сургалтанд хамруулах гэрээ байгуулсан. Гэрээний дагуу станцаас ХАБ академийн сургалтанд 5 хүн хамрагдаж байгаа.
- ТДЦ дээр гарсан үйлдвэрлэлийн осолтой холбоотой ослын дүн шинжилгээний хурал хийгдсэн.
- Станцад ХАБ -ын 3-р улирлын 3-р шатны үзлэг явуулсан.
- ЭЗЦГ-ын нийт ажилчид 2022 оны 9-р сарын 27, 28-ны өдрүүдэд БГД -ийн ЭМТ-д урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан.



## ӨӨРИЙН МЭДЭЭЛЭЛ БОЛОН ТӨХӨӨРӨМЖӨӨ НУУЦ ҮГЭЭР ХАМГААЛАХ

Нууц үг нь таны хувийн мэдээлэл, тэдгээрийг хадгалдаг төхөөрөмж болон ашигладаг онлайн үйлчилгээний авалгыг байдалг хангах үр дүнтэй аргуудан нэг юм. Хэрэв та STRONG буюу хүчтэй, сайн нууц үг ашиглах түүнийгээ зөв зохиотой хамгаалахад энэхүү зургагт хуудас багхан ч болов нэмэр болох болно. Хэрэв та дэлгэрэнгүй мэдээлэл, зөвлөгөө авахыг хүсвэл INFOSEC.MN-д хандана уу.



Гэмт хэрэгтнүүд таны данс руу нэвтрэхийг оролдох, нэвтрэхийн тулд хамгийн түгээмэл нууц үгийг ашиглах эсвэл таны социал медиа профайл дээрх мэдээллийг ашиглан тэдгээрийг таамаглах болно. Амжилттай бол тэд энэ нууц үгийг ашиглан таны бусад бүртгэлд хандахыг оролдох болно.

Гэмт хэрэгтнүүд мөн хуурамч вэб сайт руу холбосон хуурамч "финшинг" цахим шуудан үүсгэх, эсвэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан ятгах арга техник ашиглан хүмүүсийг нууц үгээ задлахыг оролдог.

Хэдийгээр та нууц үгээ хянаж байсан ч таны мэдээллийг агуулсан байгууллага мэдээлэл алдагдвал хулгайд алдах боломжтой. Гэмт этгээдүүд хулгайлагдсан хэрэглэгчийн дэлгэрэнгүй мэдээллийг (хэрэглэгчийн нэр, нууц үг гэх мэт) ашиглан бусад системд нэвтрэхийг оролдох болно.

### ХҮЧТЭЙ САЙН БУЮУ STRONG НУУЦ ҮГ ҮҮСГЭХ



Имэйл бүртгэлдээ (болон бусад чухал эрхүүддээ) хүчтэй, мартагдашгүй нууц үг ашиглаж хэвшээрэй.



Урьдчилан таамаглах боломжтой нууц үг (огноо, гэр бүл, амьтны нэр гэх мэт) ашиглахаас зайлсхий. Гэмт хэрэгтнүүдийн амархан таах боломжтой хамгийн түгээмэл нууц үгээс зайлсхий ("password" гэх мэт).



Чухал бүртгэлдүүд дээр ижил нууц үгийг дахин бүү ашигла. Хэрэв таны нууц үгийн аль нэг нь хулгайлагдсан бол гэмт хэрэгтэн таны банкны данс руу (жишээ нь) хандахыг оролдож болно.



Хэн нэгэнд таахад хэцүү, мартагдашгүй нууц үг үүсгэхийн тулд та санамсаргүй гурван үгийг нэгтгэж нэг нууц үг үүсгэж болно. (Жишээ нь Catlove@tMeat).

### ХҮЧТЭЙ САЙН БУЮУ STRONG НУУЦ ҮГ ҮҮСГЭХ

Олон компаниуд дансандаа хоёр хүчин зүйлийн баталгаажуулалтыг (мөн 2FA гэгддэг) тохируулахыг зөвшөөрдөг. Үүнийг 2FA гэж нэрлэдэг, учир нь энэ нь хоёр нууц үг эсвэл код ашиглан өөрийн данс руу нэвтрэх явдал юм; нэг нь таны мэддэг, нөгөө нь ихэвчлэн таны утас руу илгээдэг.



2FA-ийн хамгийн түгээмэл хэлбэр бол таны ухаалаг гар утсанд код илгээгдэх бөгөөд үүнийг үргэлжлүүлэхийн тулд оруулах ёстой. Та банк, цахим шуудан зэрэг чухал вэбсайтуудад 2FA-г тохируулах хэрэгтэй.



Гэмт хэрэгтэн таны нууц үгийг мэддэг байсан ч 2FA-г асааснаар таны хамгаалсан ямар ч бүртгэлд нэвтрэх гэж тэмцэнэ.

### НУУЦ ҮГЭЭ ҮРГЭЛЖ АЮУЛГҮЙ ХАДГАЛЖ ХЭВШ

Хэрэв та нууц үгээ аюулгүй газар хадгалвал тэдгээрийг санах шаардлагагүй болно. Энэ нь танд өөрийн бүх чухал бүртгэлд өвөрмөц, хүчтэй нууц үг ашиглах боломжийг олгоно.



Та нууц үгээ санахын тулд бичиж болно, гэхдээ үүнийг аюулгүй газар, харагдахгүй, (хамгийн чухал) компьютерээсээ хол байлга.



Ихэнх вэб хөтчүүд таны онлайн нууц үгийг хадгалахыг санал болгодог. Үүнийг хийхэд аюулгүй. Хөтөчүүд мөн фишинг цахим шуудангаар таныг зочлохыг оролдог "аюултай" вэбсайтуудыг илрүүлэх болно.



Та хүчирхэг нууц үг үүсгэж, хадгалахад туслах бие даасан нууц үгийн менежер програмыг ашиглаж болно.

### ХЭРЭВ ТАНЫ НУУЦ ҮГ ХУЛГАЙЛАГДСАН БОЛ ЮУ ХИЙХ ВЭ?



Хэрэв та нууц үгээ хулгайд алдсан гэж сэжиглэж байгаа бол аль болох хурдан солих хэрэгтэй.



Хэрэв та өөр ямар нэг бүртгэл дээр ижил нууц үг ашигласан бол тэдгээрийг мөн өөрчилнө үү.




Та [www.havebeenpwned.com](http://www.havebeenpwned.com) вэб сайтыг ашиглан өөрийн мэдээллийг олон нийтэд ил болгосон эсэхийг шалгах боломжтой.



## ӨӨРИЙН МЭДЭЭЛЭЛ БОЛОН ТӨХӨӨРӨМЖӨӨ ХОРТОЙ КОДНООС (ВИРУСЭЭС) ХАМГААЛАХ

Компьютер, зөөврийн компьютер, ухаалаг гар утас, таблетуудаа вирус болон бусад төрлийн хортой програмаас хэрхэн хамгаалах тухай зөвлөмжүүдийг хүргэж байна. Эдгээр аргуудыг мөрдснөөр таны төхөөрөмжүүд болон тэдгээрт хадгалгдсан мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалахад тусална.



Вирус нь компьютер, зөөврийн компьютер, ухаалаг гар утас, таблет зэрэг төхөөрөмжүүдэд хор хөнөөл учруулдаг нэг төрлийн хортой программ хангамж юм.

Таны төхөөрөмж халдварлагдсаны дараа энэхүү хортой программ хангамж нь таны өгөгдлийг хулгайж, бүрмөсөн устгах эсвэл таныг төхөөрөмжөө ашиглахад саад болж чадна.

Хортой программ агуулсан и-мэйл хавсралтыг санамсаргүйгээр татаж авах эсвэл аль хэдийн халдвар авсан USB зөөгчийг залгаснаар төхөөрөмжүүд халдвар авах боломжтой. Мөн аюултай вэб сайтад нэвтэрснээр халдвар авч болно.

Эдгээр шалтгааны улмаас та зөөврийн компьютер болон компьютер дээрээ вирусийн эсрэг программ хангамжийг байнга ашиглах нь чухал юм. Зөвхөн Google Play, Apple-ийн App Store зэрэг албан ёсны дэлгүүрээс программ суулгасан тохиолдолд ухаалаг утас болон таблетуудад вирусийн эсрэг программ шаардлагагүй.

### ВИРУСИЙН ЭСРЭГ ПРОГРАММАА АСАНА УУ.



Вирусийн эсрэг (Antivirus-AV) бүтээгдэхүүнүүд нь таны компьютер, зөөврийн компьютер эсвэл MAC-аас вирус болон бусад төрлийн хортой програмыг илрүүлж устгадаг бөгөөд үүнийг үргэлж ашиглах ёстой.



Таны вирусны эсрэг хэвийн ажиллаж байгаа эсэх, шинэчлэгдсэн эсэхийг шалгаарай. Windows болон iOS-д тохирох AV-г хангадаг суурилуулсан хэрэгслүүд байдаг.



Шинэ компьютерүүд ихэвчлэн нэмэлт AV программ хангамжийн туршилтын хувилбартай ирдэг. Эдгээр бүтээгдэхүүнүүд танд тохирох эсэхийг мэдэхийн тулд та өөрөө судалгаа хийж болно.



Таны AV программ хангамж нь интернетээс татаж авсан эсвэл USB зөөгч, гадаад хатуу диск, SD карт эсвэл бусад төрлийн зөөвөрлөгч дээр хадгалгдсан бүх шинэ файлуудыг автоматаар сканердахаар тохируулсан эсэхийг шалгаарай.



Зөвхөн албан ёсны дэлгүүрээс программ суулгасан тохиолдолд ухаалаг утас, таблет дээрээ AV бүтээгдэхүүн суулгах шаардлагагүй.



Хэрэв та компьютероо халдвар авсан гэж бодож байвал AV програмыг нээж, бүрэн скан хийнэ үү. Өгөгдсөн зааврыг дагаж мөрдөөрэй.



Хэрэв та компьютероо вирус болон хортой програмыг устгахад туслах утсаар дуудлага хүлээн авбал утсаа шууд тасална уу. (Энэ бол нийтлэг луйвар юм).

### ТӨХӨӨРӨМЖӨӨ ШИНЭЧЛЭЭРЭЙ

Өөрийн апп-ууд болон төхөөрөмжийн программ хангамжид шинэчлэлт хийхээ бүү хойшлуул; Эдгээрт вирус болон бусад төрлийн хортой програмаас хамгаалах хамгаалалт багтана.



Программ хангамжийн шинэчлэлтүүдийг ашиглах нь төхөөрөмжөө хамгаалахын тулд хийж чадах хамгийн чухал зүйлсийн нэг юм. Танаас асуух үед бүх программ болон төхөөрөмжийн үйлдлийн системийг шинэчилнэ үү.



Өөрийн AV программ хангамжийг оруулаад бүх программ хангамж, төхөөрөмжийг автоматаар шинэчлэхээр тохируулна уу.



Та үйлдвэрлэгчид дэмжихээ больсон төхөөрөмжийг шинэ загвараар солих талаар бодох хэрэгтэй. Та одоогийн төхөөрөмжөө хэр удаан албан ёсоор дэмжихийг онлайнгаар хайж болно.

### ЗӨВХӨН АЛБАН ЁСНЫ ПРОГРАММУУДЫГ СУУЛГАНА УУ



Зөвхөн албан ёсны дэлгүүрүүдээс (Google Play эсвэл App Store гэх мэт) ухаалаг утас, таблетуудад зориулсан программуудыг татаж аваарай. Албан ёсны дэлгүүрээс татаж авсан программуудыг вирус, хортой програмаас хамгаалах үүднээс шалгасан байдаг.



## "ДЦС-4" ТӨХК-Д ХҮН, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, БАРАА МАТЕРИАЛ ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ

### 6.1 Байгууллагад нэвтрүүлэх бичиг баримт:

6.1.1 Байгууллагын үндсэн ажилтанд байнгын ажлын үнэмлэх, компанид бүртгэлтэй ахмад настнууд Ахмадын хорооноос олгосон ахмадын үнэмлэх, тодорхой хугацаагаар түр ажлын байранд ажиллаж байгаа иргэд, гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа хамтран ажиллагч гадны компанийн ажилтнууд, салбарын болон сургалтын байгууллагуудаас дадлага хийж байгаа иргэдэд тус тус түр нэвтрэх үнэмлэх, ажил төрлийн шугамаар 1 удаа түр нэвтрэх гадны иргэдэд нэг удаагийн нэвтрэх үнэмлэхийг олгоно.

6.1.2 Объектод нэвтрэх тээврийн хэрэгслийн жагсаалт, холбогдох баримт бичгийн маягыг хамгаалалтын салбарт өгч, өөрчлөлт орсон тухай бүр нь шинэчилж байна.

6.1.3 Ажлын болон Түр нэвтрэх үнэмлэхийг "Ажлын болон түр нэвтрэх үнэмлэх олгох ажлын заавар" /АЗ-ЗХНА-02/-ын дагуу ЗХНА-аас, нэг удаагийн үнэмлэхийг хамгаалалтын салбараас олгоно.

6.1.4 Гадаадын иргэнийг объектод нэвтрүүлэхдээ иргэний паспорт, Монгол Улсад зорчих визний хүчинтэй хугацаа, холбогдох баримт бичгийг шалгаж, объектын захиргаанаас хариуцах хүнийг байлцуулан нэвтрүүлж, объектод орсон, гарсан тухай бүртгэл хөтөлнө.

6.1.5 Объектод нэвтрэгсдийн нэг удаагийн үнэмлэх, бараа материал гаргахыг зөвшөөрсөн баримтыг хамгаалалтын салбар дээр хурааж хадгалах ба тухай бүрт нь шалган нэвтрүүлэх бүртгэл дээр бүртгэсэн байна.

### 6.2 Компанийн объектод нэвтрэх болон гарах үед ажилтан, иргэнд зөвшөөрөл олгох, шалган нэвтрүүлэх

6.2.1 Объектод компанийн ажилтнуудыг шалган нэвтрүүлэх 1,4,8,10 дугаар постоор компаниас олгосон ажлын үнэмлэхийг шалган нэвтрүүлнэ.

6.2.2 Компанийн ажилтан нь ажлын цагаар шалган нэвтрүүлэх 4,8,10 дугаар постоор гарахдаа нэгжийн даргаасаа Гарах хуудас (АШБ-/СҮАЖ-ЗХНА-02/-17)-ыг авч шалган нэвтрүүлэх цэгүүд дэх цаг бүртгэлийн системээр бүртгүүлнэ. Нэгжийн дарга нар гарахдаа батлагдсан бүтцийн дагуу харьяалагдах удирдлага /Гүйцэтгэх захирал, Ерөнхий инженер/-д биеэр болон утсаар мэдэгдэнэ.

6.2.3 Алслагдсан аж ахуй болох ЗЦ-ийн НОВ-ын машинч нар, ИТА, ТЦ-ийн Сонгино дахь техник ус хангамжийн ажилтнууд болон ИТА, БМА-ны уурын шугам хоолойн болон дулааны шугам хоолойн засварчид, ИТА-чид объектод ажлын цагаар орж ирэх болон гарах үед цаг бүртгэх системд бүртгүүлэх шаардлагагүй зөвхөн ажлын үнэмлэхийг шалгаж шалган нэвтрүүлэх 1,4,8,10 дугаар постоор нэвтрүүлнэ.

6.2.4 Компанийн ажилтан нь объектын 4,8,10 дугаар постоор нэвтрэх болон гарахдаа заавал зөвхөн өөрийн эзэмшлийн картыг уншуулан бүртгүүлнэ.

6.2.5 Компанийн удирдлага болон холбогдох алба, хэлтэс, цех, хэсгийн дарга нартай хамтран ажиллах, компанитай танилцах, судалгаа хийх, хүсэлт уламжлах чиглэлээр уулзах хүсэлт гаргасан Монгол улсын иргэнийг тухайн нэгжийн даргын зөвшөөрлөөр шалган нэвтрүүлэх 1,10 дугаар постоор холбогдох бичиг баримтыг шалган нэвтрүүлнэ.

6.2.6 Компанитай ажил, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулсан аж ахуй нэгжийн ажилтнуудад "Гадны байгууллагаар ажил үйлчилгээ хийлгэхэд хяналт тавих журам"-ын дагуу тухайн байгууллагын хүсэлтийг үндэслэн гэрээт ажлын хугацаанд түр нэвтрэх үнэмлэхийг ЗХНА-аас олгож, шалган нэвтрүүлэх 1,7,8,10 дугаар постоор түр нэвтрэх үнэмлэх болон бусад холбогдох бичиг баримтыг шалган нэвтрүүлнэ.

6.2.7 Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан станцын үйл ажиллагаатай танилцах, сурвалжлага хийх хүсэлт гаргасан тохиолдолд Гүйцэтгэх захирлын зөвшөөрлөөр нэвтрүүлж, Хяналтын албаны байцаагч инженерүүдийн хяналтын дор ажиллуулна. Тухайн иргэнийг компанийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх ажлын байрны зураг авах, ажилтнуудтай

ярилцлага хийхийг хориглох бөгөөд судалгааны зориулалтаар мэдээлэл авах зөвшөөрлийг Гүйцэтгэх захирал олгоно.

6.2.8 Компанид дадлага хийх оюутанд ЗХНА сургуулийн хүсэлтийг үндэслэн дадлагын удирдагчийн хамтаар дадлагын хугацаанд түр нэвтрэх үнэмлэх олгож нэвтрүүлнэ.

6.2.9 "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн Ил хуваарилах байгууламж №4-т ажиллах ажилтнуудыг Ерөнхий инженерийн зөвшөөрлийн дагуу шалган нэвтрүүлэх 1,10 дугаар постоор ажлын газрын үнэмлэхийг шалган нэвтрүүлнэ.

6.2.10 Түр хугацаагаар / ажлын цагаар орж, гарах/ нэвтрэх гадаадын иргэнийг объектын удирдлага аль улсын харьяат иргэн ямар зорилгоор, хаана ямар хугацаатай ажиллах талаар албан ёсоор мэдэгдэж, баримт бичгийн хуулбарыг хамгаалалтын салбарт өгсний дараа харуулын дарга Дотоодын цэргийн үйл ажиллагааны журам код-1/211.4.2-д заасны дагуу түр зөвшөөрлөөр нэвтрүүлнэ.

6.2.11 Объектод 2 буюу түүнээс дээш хоногоор ажиллах гадаадын иргэний мэдээлэл / паспорт болон Монгол Улсын эрх бүхий байгууллагаас олгосон түр оршин суух үнэмлэх, визийн хуулбар, ангилал/-ыг бусад дагалдах материалын хамт Дотоодын цэргийн штабт 7-10 хоногийн өмнө урьдчилан хүргүүлж, Дотоодын цэргийн штабын хамгаалалтын хэлтэс тухайн иргэнийг нэвтрүүлэх тухай 05 дугаар ангид албан бичгээр чиглэл өгсөний дараа нэвтрүүлнэ.

6.2.12 Объектод үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, танилцуулга хийх хуулийн этгээд, хувь хүний бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн НАХ-ийн даргын зөвшөөрлөөр нэвтрүүлнэ.

6.2.13 Компанитай байгуулсан гэрээний дагуу засварын ажил гүйцэтгэхээр оруулах бараа материал, сэлбэг, металл хийцүүдийг хамгаалалтын салбарын 10 дугаар цэгийн гадна ирсэн үед хүлээн авах эрх бүхий ЗА, YA, НАХ-ийн инженерүүд, СБХ-ийн нятлан бодогч, нярав, ТЭЗХ-ийн нормчлолын инженер, төсвийн мэргэжилтэн нарыг шалган нэвтрүүлэх 10 дугаар постоор нэвтрүүлнэ.

### 6.3 Компанийн объектод нэвтрэх тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгох

6.3.1 Компанийн ажилчдын автомашиныг замын ачааллыг харгалзан өглөө шалган нэвтрүүлэх 1 дүгээр постоор шалгахгүйгээр дотогш нэвтрүүлж хөргөх цамхаг 1,2 баруун талын талбай / цаашид Б талбай гэх /, Түлш дамжуулах цехийн авто зогсоол /цаашид В талбай гэх /-д зогсооно.

6.3.2 ДЦС-4 ТӨХК-ийн бүртгэлтэй хүнд машин механизм буюу тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлүүдийг шалган нэвтрүүлэх 1,4,7,8,10 дугаар постоор нэвтрүүлнэ. Ажлын бус цагаар тус компанийн бүртгэлтэй тээврийн хэрэгслийг Авто аж ахуйн даргын хуваарилсан графикаар бүртгэл хийж, шалган нэвтрүүлнэ.

6.3.3 Онцгой тохиолдол буюу яаралтай ажлаар дуудагдсан ажилтаныг авч яваа аваарийн тэрэг, авто замын засвар болон бусад онц шаардлагатай үед ажилчдыг тээвэрлэн явах том оврын автобус, гал команд, цагдаа, түргэн тусламжийн машинуудыг ерөнхий инженер болон ээлжийн инженерт мэдэгдэн 4 дүгээр постоор нэвтрүүлж болно. Бусад шаардлагатай үед 4 дүгээр постоор тээврийн хэрэгсэл нэвтрэх, гарах тохиолдолд ерөнхий инженерийн зөвшөөрлийг үндэслэн Хамгаалалтын салбарын даргын шийдвэрээр нэвтрүүлж болно.

6.3.4 Ажлын өдрүүдэд хамгаалалтын салбарын 1 дүгээр постоор 07:00-07:50 цагт ажилчдын автобусыг нэвтрүүлж, автомашин зогсоол дээр ажилчдыг буулгасны дараагаар автобусыг буцааж гаргана.

6.3.5 Тус компанийн удирдлага болон алба, хэлтэс, цех, хэсгийн дарга нарын хувийн тээврийн хэрэгслийг Ерөнхий инженерийн баталсан жагсаалтын дагуу шалган нэвтрүүлэх 10 дугаар постоор нэвтрүүлж болно. Жагсаалтыг жил бүр ААА шинэчлэн батлуулж хамгаалалтын салбарт өгнө.

6.3.6 Өвлийн улиралд "ДЦС-4 ТӨХК-ийн хашаанд өвлийн дулаан зогсоол ашиглах эзэмших, шилжүүлэх журам"-ын дагуу 10 дугаар постоор

## "ДЦС-4" ТӨХК-Д ХҮН, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, БАРАА МАТЕРИАЛ ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ

нэвтрэн дотогш дулаан гражид тавихтай холбоотой ажиллагсадын хувийн автомашиныг жагсаалтын дагуу станцын шалган нэвтрүүлэх 10 дугаар постоор нэвтрүүлнэ.

6.3.7 Жагсаалтад ороогүй хувийн автомашиныг зөвхөн Ерөнхий инженерийн зөвшөөрлөөр түр 1 удаа нэвтрүүлнэ.

6.3.8 Тус компанитай засварын гэрээгээр ажиллаж байгаа гадны байгууллагын тээврийн хэрэгслийг Б зогсоолд байрлуулах бөгөөд овор ихтэй багаж хэрэгсэл, бараа материал нэвтрүүлэх тээврийн хэрэгслийг 6.2.11-д заасан эрх бүхий ажилтнууд бүртгэл хийсний дараа ЗА, ХААХ, НАХ-ийн дарга нарын зөвшөөрөл бүхий нэвтрэх хуудсаар шалган нэвтрүүлэх 10 дугаар постоор нэвтрүүлнэ.

6.3.9 Тээврийн хэрэгслийг бүрэн зогсолт хийсний дараа бичиг баримтыг шалгаж, жолоочийг байлцуулан ачааны хэсэг кабиныг шалгах ба ачаатай машины ачааг дагалдах бичиг баримттай нь тулган шалган нэвтрүүлнэ.

6.3.10 Компанитай ахуйн байр болон түрээсийн талбай ашиглах

гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн хүсэлтийг үндэслэн тухайн компанийн тээврийн хэрэгслийг хязгаарлалттай тоогоор Ерөнхий инженерийн зөвшөөрлөөр шалган нэвтрүүлэх 8 дугаар постоор нэвтрүүлнэ.

6.3.11 Компанийн нутаг дэвсгэрт зохион байгуулагдаж буй хурал, уулзалт, олон нийтийн арга хэмжээнд оролцож буй зочид төлөөлөгчдийн тээврийн хэрэгслийг Ерөнхий инженерийн зөвшөөрлөөр, НАХ-ийн дарга нэвтрэх бичгийг олгоно.

6.3.12 "ДЦС-4"ТӨХК, ТӨБЗГ-тай хамтарсан гэрээний дагуу түрээсээр худалдаа, үйлчилгээ явуулж буй байгууллагын гэрээнд тусгагдсан тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх 8,10 дугаар постоор нэвтрүүлнэ.

6.3.13 Борлуулах бараа материал, хоёрдогч түүхий эд, ажил үйлчилгээ зорлогын эд анги ачих тээврийн хэрэгслийг дотогш нэвтрүүлэх зөвшөөрлийг Гэрээ болон зөвшөөрлийг үндэслэн БМА-ны дарга олгоно.

6.3.14 Зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтнуудыг эзгүй үед тэднийг орлох эрх бүхий албан тушаалтан зөвшөөрөл олгоно.

Харуулын хэсэг

### ЗӨВ ХООЛЛОЛТ

тавагны заримаас эхэлнэ.

**Уураглаг хөмс – тавагны ¼:**  
Төрөл бүрийн мах, загас, тахиа, шош, буурцаг, вандуй, өндөг, дүлп, сүү, цагаан идээ

**Жимс, ногоо – тавагны ½:**  
Төрөл бүрийн хүнсний ногоо, жимс, жимсгэнэ /Жич: Төмс хүнсний ногоо биш гэдгийг санаарай/

**Үр тариа – тавагны ¼:**  
Төрөл бүрийн будаа, гурил, гоймон, талх, шош буурцаг, буудайн үр, төмс

**Ургамлын гаралтай тос – бага хэмжээгээр**  
Оливны тос, шар буурцгийн тос, эрдэнэшишийн тос, наранцэцгийн тос, самрын тос

Өдөрт 4 - 6 аяга ус уугаарай.

Өдөрт давсыг 5 гр - с хэтрүүлэн хэрэглэж болохгүй.

Өдөрт элсэн чихрийг 20-30 гр-с хэтрүүлэн хэрэглэж болохгүй.

**ХЯЗГААРТАЙ ХЭРЭГЛЭХ ХҮНС**  
Төрөл бүрийн газтай ундаа  
Чихэрлэг ундаа  
Түргэн хоол  
Лаазалсан бүтээгдэхүүн  
Чипс  
Шоколад  
Чихэр  
Зайрмаг

/Эрчим зоог цайны газар/

## АРЬС, ҮС, ХУМСНЫ МӨӨГӨНЦӨРТ ӨВЧИН

Арьсны үлд өвчин нь мөөгөнцөр хэмээх өвөрмөц үүсгэгчээр үүсгэгддэг бөгөөд хүнээс хүнд эсвэл халдвартай амьтнаас хүнд шууд болон шууд бус /өвчтэй хүний хэрэглэсэн сам, алчуур, углааш зэрэг ахуйн хэрэглээний зүйлс, үсчин, усан сан гэх мэт/ замаар халддаг нийгмийн халдварт өвчин юм.



Арьсны мөөгөнцөрт өвчнүүд нь нийгмийн эрүүл мэндийн томоохон асуудал болж байна. Уг өвчин нь архаг болон хурц явцтай. Насанд хүрэгчдэд халдварлалт харьцангуй бага харин бага насны хүүхдийн арьсны эвэрлэг давхаргын гүйцэд хөгжөөгүй, сийрэг байдлаас хамаарч халдварлалт илүү өндөр байна. Мөөг нь чийглэг, сул хүчиллэг Ph 4.5-5 орчинд, агааргүй орчинд сайн үржиж чаддаг тул хүүхэд өвчлөх боломж илүү өндөр байдаг. Мөөгөнцрийн мицелл нь 60-80°-ийн хэмд 20-30 минутанд устдаг гэж үздэг. Харин хүйтэн болон хэт ягаан туяанд тэсвэртэй. Мөөгөнцрийн халдварт өртөх нь биеийн эсэргүүцэл сул байх, тэжээлийн дутагдал, бага нас, хөлрөмтгий байх, арьсны бүрэн бүтэн байдал алдагдах гэх мэт дотоод хүчин зүйлээс хамаарна. Халдвар гэр бүлийн гишүүдэд өвчтөний хувцас, цагаан хэрэглэл, алчуур, бие угаагч зэргээр дамжиж халдварлана. Түүнээс гадна үсчин, нийтийн халуун усны газар, гутал хувцас сольж өмсөх зэрэг нь халдвар тарах эрсдэлт хүчин зүйл болдог. Биеийн мөөгөнцөрт өвчин өсвөр насныханд, бага насныханд хуйхны үлд, насанд хүрэгчдэд тавхайн мөөгөнцөрт өвчин тохиолдох нь элбэг байдаг. Гэр бүлийн гишүүдийг бүрэн гүйцэт эмчлэхгүй бол өвчин дахих боломжтой. Мөн халдвараар өвчилсөн хүүхдийг сургууль, цэцэрлэгээс чөлөөлөх шаардлагатай байдаг.



### ЭРСДЭЛТ ХУЧИН ЗҮЙЛС:

Гадаад хүчин зүйл /халдварт өвчний шууд ба шууд бус хавьталтай байх, халуун чийглэг уур амьсгал/, дотоод хүчин зүйл /шим тэжээлийн дутагдалтай байх, дархлаа сул байх, бага насны хүүхэд, хөлрөмтгий хүмүүс

### УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ:

- ✓ Үйлчилгээний байгууллагуудыг эрүүл ахуйн шаардлага хангуулах
- ✓ Үйлчлүүлэгчийн хэрэглэсэн эд зүйлсийг стандартын дагуу халдваргүйжүүлэх
- ✓ Малын халдварт мөөгөнцөрт өвчнийг мал эмнэлэгт мэдээлэх, мал амьтныг эмчлэх

### ИЛРҮҮЛЭГ, ОНОШЛОГООНЫ АРГАЧЛАЛ:

Эмнэлзүй болон лабораторийн шинжилгээнд үндэслэн өвчнийг оношлож, зааврын дагуу эмчилгээнд хамруулах, халдварын эрсдэлтэй хүнийг илрүүлнэ. Үүнд – тамирчид, таргалалт бүхий иргэд, халуун усны газар, саун бассейнаар тогтмол үйлчлүүлэгсэд

### ЗОВИУР, ЭМНЭЛЗҮЙН ШИНЖ:

- Арьсан дээр /төрлүүдээс хамаарч байрлал, шинж тэмдэг өөр/ тууралт гарна, бага зэрэг загатнана
- Хуйхны үлдийн үед үс унана.
- Арьсан дээр гарсан тууралт бүхий хэсгээс хайрс хогжруу ихээр үүсэх
- Хумсны өнгө, хэлбэр, гадаргуу өөрчлөгдөнө.

### ОНОШЛОГОО:

- Зовиур
- Бодит үзлэг
- Лаборатори шинжилгээ
- Багажийн шинжилгээ

### ЭМЧИЛГЭЭ:

Эмийн бус эмчилгээ

Арьсны ариун цэвэр сайн сахих /тогтмол усанд орж, арьсыг хуурай байлгах/

Халдварлагдсан эд зүйлсийг халдваргүйжүүлэх /тавхайн үлд өвчний үед гутал оймсыг ариутгахаар хлоргексидиний болон мөөгөнцрийн эсрэг эмтэй цацлагыг гутал уруугаа 7 хоногт 1 удаа цацах, мөөгөнцрийн эсрэг үйлдэлтэй тусгай зориулалтын гутал ариутгагч бодис хэрэглэх/

Эмийн эмчилгээ

Өвчнийг богино хугацаанд гаж нөлөө багатайгаар эмчлэх зорьдог бөгөөд мөөгөнцөр бүрэн эмчлэгддэг өвчин юм. Стандарт эмчилгээний дагуу эмчилнэ.

Мэс засал эмчилгээ

Хумсны мөөгөнцрийн үед өвчилсөн хумсны ялтасыг мэс заслын аргаар авч, хумсны хэвтэшийг хусаж цэвэрлэнэ, эдгэрэлт хурдасна.

Эмчлэгдсэний дараа харъяа эмчийн хяналтанд 4-6 долоо хоног байна.

Эмнэлэгийн хэсэг